



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар A/201

Арвайхээр

Шинэ вакцин нэвтрүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын “Дархлаажуулах арга хэмжээ зохион байгуулах тухай” 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/119 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Пневмококкийн шалтгаант уушигны хатгалгаа өвчнөөс сэргийлэх пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар 2 сартай хүүхдийг дархлаажуулах арга хэмжээг товын дагуу, халдварт саа өвчнийг дэлхий нийтэд устгах зорилтын хүрээнд халдварт саагийн идэвхгүйжүүлсэн вакцинаар 5 сартай хүүхдийг дархлаажуулах арга хэмжээг аймгийн хэмжээнд 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дарга, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


2. Дархлаажуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин, Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар дархлаажуулах тов, вакциныг хэрэглэх зааврыг мөрдөж, ажиллахыг сум, өрхийн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Шинэ вакцин нэвтрүүлэх хүрээнд дархлаажуулалтын талаарх хүн амын мэдлэг, хандлагыг тандан, пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины ач холбогдлыг эрүүл мэндийн ажилтан, эцэг эх, асран хамгаалчдад олон нийтийн мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100455

Аймгийн Засаг даргын 2019 оны 03
дугаар сарын 02-ны өдрийн 4/201 дугаар
захирамжийн хавсралт

ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИН, ХАЛДВАРТ СААГИЙН
ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1. Бэлтгэл ажлын хүрээнд				
1.1	Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин (ПЭВ-13), халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг тухайн орон нутагт нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулах	3 дугаар сар	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар,
1.2	Орон нутгийн шийдвэр гаргагч нарт шинэ вакцины талаар мэдээллийг хүргэх	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	
1.3	Харъяаллын нутаг дэвсгэрт оршин суудаг 2019 оны 4 дүгээр сард 2, 5 сартай хүүхдийн судалгааг нарийвчлан гаргах	3 дугаар сар	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар,
1.4	ПЭВ-13, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин, дагалдах хэрэгслийг хуваарилах, эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуу лалтын алба
1.5	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хүчин чадлыг үнэлэх	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуу лалтын алба
1.6	Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан ПЭВ-13, халдварт саагийн сургалтын гарын авлагыг түгээх	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуу лалтын алба
1.7	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эмч, мэргэжилтэн, вакциinator сувилагч нарыг ПЭВ-13, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг нэвтрүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулах	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	ХӨСҮТ, Дархлаажуу лалтын алба
1.8	Дархлаажуулалтын нэгжийн үйл ажиллагааны бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгөх, давтан хяналт хийх	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	
1.9	Хэвлэлийн бага хурал хийж, иргэдэд мэдээлэл түгээх	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	
1.10	Дархлаажуулалтын чиглэлээр ажиллаж буй эмч, вакциinator сувилагч нарт харилцааны ёс зүй, эцэг эхэд дархлаажуулалтын чиглэлээр зөвлөгөө өгөх чадварыг ажлын байранд нь сургах	3 дугаар сараас эхлэн	Эрүүл мэндийн газар Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	ХӨСҮТ, Дархлаажуу лалтын алба
1.11	Дархлаажуулалтын ач холбогдол, вакцины товын талаар эрүүл мэндийн ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчдад мэдээлэл, зөвлөмжийг хүргэх, зөвлөгөө өгөх	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	ХӨСҮТ, Дархлаажуу лалтын алба

1.12	Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр хүн амд хүргэх ажлыг зохион байгуулах	3 дугаар сар	Эрүүл мэндийн газар Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	ХӨСҮТ, Дархлаажуулалтын алба
2. Пневмококкын эсрэг 13 цэнт вакцин, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг нэвтрүүлэх үеийн болон нэвтрүүлсний дараах үйл ажиллагаа				
2.1	Аймгийн хэмжээнд халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар 5 сартай хүүхдийг, ПЭВ-13 вакцинаар 2 сартай хүүхдийг товын дагуу дархлаажуулах	4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
2.2	Хамрагдсан хүүхдийг дархлаажуулалтын цахим бүртгэлийн санд бүртгэх, мэдээллийг нэгтгэх, хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах	4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
2.3	ПЭВ-13 болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины дараах ДДУХ-ийг журмын дагуу тандах, бүртгэх, шаардлагатай хариу арга хэмжээ авах	4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
2.4	Дархлаажуулалтын нэгжүүдийн үйл ажиллагаа, шинэ вакциныг хэрэглэх чиглэлээр явцын дэмжлэгт хяналт хийх, ажлын байрны сургалт зохион байгуулах	5 дугаар сараас эхлэн	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуулалтын алба
2.5	ПЭВ-13 болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг нэвтрүүлсэн үйл ажиллагааны тайланг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах	6 дугаар сараас эхлэн	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуулалтын алба
2.6	Пневмококкийн шалтгаант халдвар болон цочмог сул саажилтын тандалтын үйл ажиллагааны талаар хүүхдийн эмч, сум, өрхийн эмч, багийн бага эмч нарыг сургах, давтан сургах	6 дугаар сараас 9 дүгээр сар	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуулалтын алба